



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Монголбанкинд 250 хэрэглэгчийн эрхтэй microsoft office 365 business програм хангамжийн лиценз нийлүүлэх,**

Тендер шалгаруулалтын дугаар: **Б -2019/1**

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос ажлын хэрэгцээнд зориулан 250 хэрэглэгчийн эрхтэй microsoft office 365 business програм хангамжийн лиценз нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 (тавин мянга) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд (дансны нэр: тендерийн хороо) тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна:

Борлуулалтын хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас багагүй байна

Санхүүгийн тайлан ирүүлэх жил: 2017, 2018 он /2017 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан тайлан ирүүлэх/

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгох үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Тендерийг 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 10 цаг 40 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МОНГОЛБАНК

Бага тойруу-3, 15160, Улаанбаатар хот,

Монголбанкны “Өргөтгөл” байрны 2 дугаар давхар, 37 тоот өрөө,

Утас: (976-11) 311039, факс: (976-11) 311471